



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 0159

Чингис хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1 дэх заалт, Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Хоёрдугаар хуралдааны 04 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрлэн сумын 2025 оны сумын орон нутгийн төсвөөс санхүүжигдэх “Өлзийт, Тахилгат тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” ХЭАХЭСЗДТГ/20250103011 худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	А.Боргил – Хэрлэн сумын Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Э.Золбаяр- Барилга, дэд бүтэц, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Ж.Алтантөгс – Бэлчээр, газар тариалан, мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн
	Э.Одхүү – Иргэний төлөөлөл
	С.Болор-Эрдэнэ –Хэрлэн сумын иргэдийн хурлын төлөөлөгч

2.Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу шуурхай зохион байгуулж гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (А.Боргил)-д даалгасугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР